Хараат бус хөндлөнгийн аудит баталгаажуулалт,
Санхүүгийн тайлан нягтлах, Санхүүгийн зөвлөх, Санхүүгийн дотоод аудит

ХАРААТ БУС АУДИТЫН ТАЙЛАН

"Алтан гэрэгэ финанс ББСБ" ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн тайлангийн тухай

2025 он

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Хийморь хотхон, 4-7 байр, 7-1 тоот
Утас: 90098901, 95957791
И-Мэйл: coo@mindug.mn, director@mindug.mn

"Алтан гэрэгэ финанс ББСБ" ХХК

2024 оны жилийн эцсийн
санхүүгийн тайлан

ХАРААТ БУС АУДИТЫН ТАЙЛАН

АГУУЛГА

1. Хараат бус аудитын дүгнэлт
2. Аудитлагдсан санхүүгийн тайлан
    - Санхүү байдлын тайлан
    - Орлогын дэлгэрэнгүй тайлан
    - Өмчийн өөрчлөлтийн тайлан
    - Мөнгөн гүйлгээний тайлан
3. Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулга
    - Компаний үйл ажиллагааны талаарх товч танилцуулга
    - Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд
    - Нэмэлт тодруулга

МИНДУГ АУДИТ

ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

2025 оны 01 сарын 28 өдөр Дугаар 24-Д/03 Улаанбаатар хот

“АЛТАН ГЭРЭГЭ ФИНАНС ББСБ” ХХК-ИЙН УДИРДЛАГАД

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн тухай тайлан

Дүгнэлт

Бид **“Алтан гэрэгэ финанс ББСБ” ХХК**-ийн /цаашид компани гэх/ 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон баланс, орлого үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй, бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, **“Алтан гэрэгэ финанс ББСБ” ХХК** -ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн гаргасан Сангийн сайдын заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартын дагуу бид хүлээх үүрэг хариуцлагаа энэхүү аудитын тайлангийн Аудиторын үүрэг хариуцлага хэсэгт багтаан харуулсан. Бидний хувьд, санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн стандартын шаардлагуудын дагуу тус Компаниас хараат бус бөгөөд бид эдгээр шаардлагын ёс зүйтэй холбоотой бусад үүрэг хариуцлагаа биелүүлсэн болно. Бидний олж авсан нотлох зүйл нь бидний дүгнэлтэд зохистой үндэслэл болж чадна гэдэгт итгэлтэй байна.

Тасралтгүй үйл ажиллагааны зарчимтай холбоотой асуудлууд

Тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой материаллаг тодорхой бус байдал үүссэн тохиолдол бидэнд ажиглагдаагүй болно.Тус компани нь цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулна гэсэн төсөөллөөр тайлангаа бэлтгэсэн байна.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Хийморь хотхон, 4-7 байр, 7-1 тоот
Утас: 90098901, 95957791
И-Мэйл: coo@mindug.mn, director@mindug.mn

МИНДУГ АУДИТ
БАТЛАН ХЯНАГЧ

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр, тайлант жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц асуудлууд нь аудитын гол асуудлууд болдог. Эдгээр асуудлууд нь санхүүгийн тайланг бүхэлд нь хамарсан, аудитын ажлын агуулга болон дүгнэлтийн хэлбэрт тусгалаа олсон бөгөөд эдгээр асуудал дээр бид тусад нь санал дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Бусад мэдээлийн хувьд удирдлага хариуцах бөгөөд жилийн санхүүгийн тайланд орсон боловч бидний гаргасан аудиторын тайланд ордоггүй. Бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилт гаргадаггүй.

Санхүүгийн тайланд засаглах удирдлага болон удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу гаргаж, үнэн зөв толилуулах нь бидний үүрэг хариуцлага бөгөөд энэхүү үүрэг, хариуцлагад аливаа алдаа, залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайланг бэлтгэх, толилуулахтай холбоотой дотоод хяналтын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх үүрэг хариуцлагууд багтана.

Ийнхүү санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь компанийн тасралтгүй үргэлжлэх чадварыг үнэлэх, тодруулга гаргах, компаниа татан буулгах эсвэл үйл ажиллагааг нь зогсоох, өөр бусад арга хэмжээ авах зорилгогүй байгаа тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчмын үндэслэлийг ашиглах болон тухайн зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулга хэлбэрээр бэлтгэх зэрэг үүрэг хүлээнэ.

Засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний үүрэг, хариуцлага бид хийж гүйцэтгэсэн аудитаа үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм. АОУС-аар санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилтэй илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй магадлагаа олж авахын тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон санхүүгийн тайлангийн тодруулгыг нотлох зүйл олж авах горимуудыг гүйцэтгэх ажил болно. Аудитын явцад компанид хэрэглэгдэж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцоолол, санхүүгийн тайлангуудын бодитой эсэхэд үнэлэлт өгөв. Мөн бид мэргэжлийн үл итгэх байдлыг баримтлан ажилласан. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авна. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд

хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах зэрэг орно.

- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаарх ойлголт олж авдаг.
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол, тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Компанийн тасралтгүй байх зарчимд материаллаг тодорхойгүй байдалд эргэлзээ үүссэн бол тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулж, тодруулгад хангалттай дурдаагүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудитын тайлан гарах өдөр хүртэл олж авсан баримт нотолгоондоо үндэслэн дүгнэлтээ гаргасан.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж, санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлсон.

Энэхүү тайлан нь Монгол улсын “Компанийн тухай” хуулийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болон хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан ба аливаа өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Бид энэхүү Аудитын ажлыг хийж гүйцэтгэж аудитын тайланг бэлтгэсэн болно.

УЛААНБААТАР ХОТ

МИНДУТ АУДИТ ХХК

С.ЭНХТӨР

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

2613379 ХНТ5466

"АЛТАН ГЭРЭГЭ ФИНАНС ББСБ" ХХК
2023 болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх
Санхүүгийн байдлын тайлан

	Тод	2024 /төгрөгөөр/	2023 /төгрөгөөр/
Хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4	62,469,233	137,848,751
Богино хугацаат хөрөнгө оруулалт, цэвэр	-	-	-
Зээл,цэвэр	5	2,406,458,086	2,181,939,156
Бусад авлага	6	-	-
Бусад санхүүгийн бус хөрөнгө	6	293,038,497	287,627,197
Үндсэн хөрөнгө, цэвэр	7	3,151,103	905,494
Биет бус хөрөнгө, цэвэр	-	-	-
Хөрөнгийн дүн		**2,765,116,919**	**2,608,320,598**
Өр төлбөр ба өөрийн хөрөнгө			
Өр төлбөр			
Санхүүгийн өр төлбөр	8	372,821	587,480
Татвар, НДШ-ийн өр төлбөр	-	16,017,062	4,011,371
Өр төлбөрийн дүн		**16,389,883**	**4,598,851**
Өөрийн хөрөнгө			
Хувьцаат капитал	9	2,500,000,000	2,500,000,000
Дахин үнэлгээний нөөц		-	-
Тухайн жилийн ашиг		145,005,289	35,326,449
Өнгөрсөн жилийн алдагдал		103,721,747	68,395,298
Эрсдлийн сангийн нөөц		-	-
Нийгмийн хөгжлийн сан		-	-
Өөрийн хөрөнгийн дүн		**2,748,727,036**	**2,603,721,747**
Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн		**2,765,116,919**	**2,608,320,598**

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

"АЛТАН ГЭРЭГЭ ФИНАНС ББСБ" ХХК
2023 болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилүүдийн
Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

	Тод	2024 /төгрөгөөр/	2023 /төгрөгөөр/
Хүүгийн орлого	10	378,795,962	273,311,237
Хүүгийн зардал	11	-	-
Хүүний бус цэвэр орлого		**378,795,962**	**273,311,237**
Болзошгүй эрсдлийн зардал	12	-	48,295,686
Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого		**378,795,962**	**225,015,551**
Бусад орлого		9,166,734	4,414,125
Бусад орлого, олз		-	-
Бусад зардал		226,845,329	193,665,384
Бусад зардал, гарз	-	-	10,171
Татварын өмнөх ашиг, алдагдал		**161,117,368**	**35,754,121**
Орлогын татварын зардал	13	16,112,079	427,672
-			
Тайлант жилийн цэвэр ашиг		**145,005,289**	**35,326,449**
Бусад дэлгэрэнгүй орлого:			
Бусад хөрөнгийн үнэ цэнийн цэвэр өөрчлөлт		-	-
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого		**145,005,289**	**35,326,449**

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

"АЛТАН ГЭРЭГЭ ФИНАНС ББСБ" ХХК
2023 болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилүүдийн
Өмчийн өөрчлөлтийн тайлан

	Тод	Хувьцаат капитал /төгрөгөөр/	Дахин үнэлгээний нөөц /төгрөгөөр/	Хуримтлагдсан ашиг (алдагдал) /төгрөгөөр/	Эрсдлийн сангийн нөөц /төгрөгөөр/	Өмчийн дүн /төгрөгөөр/
2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр		**1,900,000,000**	**-**	**68,395,298**	**-**	**1,968,395,298**
Эхний үлдэгдлийн залруулга		-	-	-	-	-
Тайлант жилийн цэвэр ашиг		-	-	35,326,449	-	**35,326,449**
Эрсдлийн сангийн тохируулга		-	-	-	-	-
Нэмж гаргасан хувьцаа		600,000,000	-	-	-	**600,000,000**
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр		**2,500,000,000**	**-**	**103,721,747**	**-**	**2,603,721,747**
Эхний үлдэгдлийн залруулга		-	-	-	-	
Тайлант жилийн цэвэр ашиг		-	-	145,005,289	-	**145,005,289**
Эрсдлийн сангийн тохируулга		-	-	-	-	-
Нэмж гаргасан хувьцаа		-	-	-	-	-
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр		**2,500,000,000**	**-**	**248,727,036**	**-**	**2,748,727,036**

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

"АЛТАН ГЭРЭГЭ ФИНАНС ББСБ" ХХК
2023 болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилүүдийн
Мөнгөн гүйлгээний тайлан

	2024 /төгрөгөөр/	2023 /төгрөгөөр/
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого:	**1,223,061,678**	**1,113,341,843**
Зээлийн эргэн төлөлтийн орлого	1,202,641,743	1,109,734,843
Бусад орлого	20,419,935	3,607,000
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага:	**1,297,738,541**	**1,726,805,338**
Үндсэн ба нэмэгдэл цалин	147,358,459	124,909,141
Татвар НД-д төлсөн	62,933,631	60,378,062
Бараа материал худалдан авсан	-	-
Зээлтэй холбогдон гарсан	1,067,421,000	1,312,900,000
Мэргэжлийн үйлчилгээнд төлсөн	-	-
Зохицуулалтын үйлчилгээнд төлсөн	-	-
Бусад үйлчилгээнд төлсөн	20,025,451	228,618,136
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	**(74,676,863)**	**(613,463,495)**
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого:	**2,257,675**	**600,826,231**
Хөрөнгө оруулалтаас хүлээн авсан	-	600,047,000
Ногдол ашгийн орлого	-	-
Хандив	-	-
Бусад	2,257,675	779,231
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага:	**2,959,700**	**-**
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,959,700	-
Бусад		
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	**(702,025)**	**(12,637,264)**
Валютын ханшийн зөрүү	(629)	10,171
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(75,379,518)	(12,627,093)
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	**137,848,751**	**150,486,015**
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	**62,469,233**	**137,848,751**

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

АЛТАН ГЭРЭГЭ ФИНАНС ББСБ
2023 болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилүүдийн
Санхүүгийн тайлангийн тодруулга

1. Үйл ажиллагаа ба зохион байгуулалт

"Алтан гэрэгэ финанс ББСБ" ХХК нь 2015 оны 8 дугаар сард Монгол Улсын компанийн тухай хуулийн дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр үүсгэн байгуулагдсан, Монгол Улсын хуулийн этгээд юм.

Банк бус санхүүгийн байгууллага нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2015 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн ТЗ 101/509 тоот тусгай зөвшөөрлийн гэрчилгээгээр Банк бус үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авснаар зээлийн үйл ажиллагааг явуулж эхэлсэн.

Албан ёсны хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Эн Си Пи барилгын 203 тоот.

Монгол улсын бүртгэлийн албанд бүртгэгдсэн аж ахуйн нэгжийн 5755263 тоот регистр, улсын бүртгэлийн 9015003089 дугаартай.

"Алтан гэрэгэ финанс ББСБ" ХХК-ийн хувьцааг 100 хувь Гун овогтой Ганбаяр /ЮД92024792/эзэмшдэг.

Хувьцаа эзэмшигчийн 2024 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн шийдвэрээр хувьцаат капиталыг 600.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр хувьцаат капитал 2.5 тэрбум төгрөг болсон.

Компанийн Ерөнхий захирлаар Ц.Сувд-Эрдэнэ, Гүйцэтгэх захирлаар Д.Батцэцэг, Нягтлан бодогчоор Б.Уранзаяа, Зээлийн мэргэжилтнээр М.Гэрэлтуяа, Ц.Болор-Эрдэнэ нар тус тус ажилладаг.

2. Санхүүгийн тайлан бэлтгэх үндсэн зарчим

Санхүүгийн тайлангийн нийцэл

Хавсаргасан санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д нийцүүлэн Санхүүгийн Зохицуулах Хорооноос батлан гаргасан заавар, журмын дагуу бэлтгэсэн.

Үнэлгээний суурь

Санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчимд үндэслэн бэлтгэсэн.

Үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан гаргасан валют

Үйл ажиллагааны валют нь Монгол Улсын үндэсний валют төгрөг юм. Хавсаргасан санхүүгийн тайланг төгрөгөөр бэлтгэсэн.

Санхүүгийн тайлан бэлтгэх төсөөлөл

Компани одоо болон алс ирээдүйд үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөлд үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэсэн.

Тооцоолол ба үнэлэмжийн хэрэглээ

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал тооцоолол, үнэлгээ хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлгээ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэглээ болон бүртгэсэн хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын зүйлсийн дүнд нөлөөлдөг. Гүйцэтгэлээрх үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно.

Тооцоолол, түүнийг хийхэд хэрэглэсэн таамаглал, төсөөллийг байнга хянадаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийн нөлөөллийг өөрчлөлт хийгдсэн тухайн жилд болон ирээдүйн тайлант жилүүдэд тусгадаг.

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд

Компани нь доор хураангуйлсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг энд үзүүлсэн бүх тайлант жилүүдэд тогтвортойгоор хэрэглэсэн.

Гадаад валютын гүйлгээ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлж, төгрөг валютаар давхар бүртгэдэг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөрийг тайлагналын өдрийн хаалтын ханшаар төгрөг руу хөрвүүлэн илэрхийлнэ. Гадаад валютаар илэрхийлэгдсэн ба бодит үнэ цэнээрээ хэмжигдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг уг бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн албан ханшаар үйл ажиллагааны валют руу хөрвүүлэн илэрхийлдэг. Гадаад валютын ханшийн зөрүүг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Гадаад валютаарх түүхэн өртгөөрөө хэмжигдсэн мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ гарсан өдрийн валютын ханшаар тайлагнадаг.

Санхүүгийн хэрэглүүр

(i) Ангилал

Арилжаалах зориулалттай санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр нь Компаний богино хугацааны дотор худалдах зорилгоор худалдан авч, эзэмшиж байгаа өрийн бичиг, өмчийн үнэт цаас, болон бусад үнэт цааснуудаас бүрддэг. Эдгээрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тухайн жилийн үр дүнгээр тусгадаг.

Бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүдийг ийнхүү ангилахдаа 1) энэхүү ангилал нь нягтлан бодох бүртгэлийн бодит байдалтай үл нийцэх байдлыг бууруулдаг, цаашлаад арилгадаг, 2) холбогдох санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр нь ямар нэгэн бүлэг санхүүгийн хөрөнгийн, санхүүгийн өрийн эсвэл хоёулангийн бүлэгт багтдаг ба бичиж баримтжуулсан эрсдлийн менежментийн эсвэл хөрөнгө оруулалтын стратегийн дагуу тэдгээрийн үр өгөөжийг бодит үнэ цэндээр нь тулгуурлан үнэлж, удирддаг, 3) иж бүрдэл байх буюу иж бүрдлээс нь салгахгүй байх шалгуурт нийцээгүй дериватив эсэхийг харгалзан үзнэ.

Богино хугацаанд арилжааны зорилгогүй, харилцагчдад олгосон мөнгийг зээл ба урьдчилгаа гэж үздэг. Зээл ба урьдчилгаа нь харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаанаас бүрдэх ба буцаан цуглуулах боломжтой дүнгээр буюу эрсдлийн санг хассан дүнгээр тайлагнадаг. Эрсдлийн санг Сангийн Яам ба Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтран баталсан “Активыг ангилах, активын эрсдлийн санг байгуулах зарцуулах журам”-ын дагуу сар бүр тооцдог бөгөөд тайлант жилийн эцэст Сангийн Яам ба Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтран баталсан “Банкны нягтлан бодох бүртгэлийн заавар”-ын дагуу тооцдог.

Арилжаалах боломжтой хөрөнгө гэж арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа болон гэрээний хугацааг дуустал эзэмших активаас бусад санхүүгийн хөрөнгийг хэлнэ.

(ii) Анхдагч хүлээн зөвшөөрөлт

Компани нь санхүүгийн хэрэглүүрийн гэрээний нэг тал болох үед санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анх үүсэх үеийн бодит үнэ цэнээр бүртгэх ба бодит үнэ цэнийг нь тухайн жилийн үйл ажиллагааны ашиг алдагдлаар бүртгэхгүй хөрөнгө ба өр төлбөрийн хувьд бодит үнэ цэн дээр тэдгээрийг худалдан авах эсвэл гаргахтай шууд холбоотой гарсан зардлыг нэмж бүртгэнэ.

(iii) Дараах үеийн хүлээн зөвшөөролт

Арилжааны бус санхүүгийн өр, зээл болон авлагууд, гэрээний хугацаа дуусах хүртэл эзэмших хөрөнгүүдийг хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр бүртгэдэг. Хорогдуулсан өртөгийг бодит хүүгийн аргаар тооцон хорогдуулна. Урамшуулал ба хөнгөлөлт, ажил гүйлгээний өртөгийг тухайн хэрэгслийн дансны үнэд оруулах ба бодит хүүгийн хувь хэмжээнд үндэслэн хорогдуулдаг.

Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийг бүртгэлээс хасах

(i) Санхүүгийн хөрөнгө

Компани тухайн санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн гүйлгээг авах гэрээний эрхийн хугацаа дууссан, эсвэл тухайн хөрөнгөөс орж ирэх мөнгөн гүйлгээг эзэмших гэрээний эрхээ бусдад шилжүүлсэн, эсвэл уг мөнгөн гүйлгээг нэг ба түүнээс дээш этгээдэд тодорхой шалгуур хангасан тохиолдолд төлөх үүрэг хүлээх болсон, эсвэл хөрөнгийг эзэмшихтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг бусдад бодитойгоор шилжүүлсэн бол санхүүгийн хөрөнгийг данснаас хасна.

Компаний хувьд өмнө нь бүртгэлдээ тусгасан байсан санхүүгийн хөрөнгийг бусдад шилжүүлэх боловч тэдгээр санхүүгийн хөрөнгийн бараг бүх өгөөж болон эрсдэлийг хадгалсан хэвээр үлдэх хэлцэл хийх тохиолдол байдаг. Харин санхүүгийн хөрөнгийг эзэмшихтэй холбоотой өгөөж болон эрсдлийг шилжүүлээгүй ч бас өөртөө хадгалж үлдээхгүйгээр тохирсон хэлцлийн хувьд тухайн хөрөнгийг хяналт тавьж чадахгүй тухайлбал тухайн шилжүүлсэн хөрөнгийг гуравдагч этгээдэд худалдаж чадахгүй болсон бол шилжүүлсэн хөрөнгийг бүртгэлээс хасдаг. Харин хөрөнгөнд хяналт тавих эрхийг хадгалж үлдсэн бол Компани уг хөрөнгийг өөрийн оролцооны хэр хэмжээгээр өөрөөр хэлбэл шилжүүлсэн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтөнд хэдий хэмжээгээр өртсөн хэвээр байгаа хувь хэмжээгээр нь бүртгэлдээ хэвээр үлдээнэ.

Дээрх бүртгэлээс хасах шалгуурыг заавал тухайн хөрөнгийн хувьд бүхэлд нь эсвэл бүлэг ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгийн хувьд хэрэглэнэ гэхээсээ илүү хэрвээ тохиромжтой бол хөрөнгийн зарим хэсгийг хэсэгчлэн шилжүүлэх үед ч баримтална. Хөрөнгийн хэсгийг шилжүүлэхэд тэрхүү хэсэг нь тусгайлан тогтоосон мөнгөн урсгал, тухайн хөрөнгийн тодорхой хувь хэсэг эсвэл тусгайлан тогтоосон мөнгөн урсгалын тодорхой хувь хэсэг байх ёстой.

(ii) Санхүүгийн өр төлбөр

Санхүүгийн өр төлбөрийг гэрээний үүрэг биелэгдсэн, цуцлагдсан эсвэл гэрээний хугацаа дууссан тохиолдолд бүртгэлээс хасна. Хэрэв одоогийн санхүүгийн өрийг хуучин зээлдүүлэгчээсээ өөр санхүүгийн өрийн хэрэгслээр солих тохиолдолд шинэ санхүүгийн өрийг хуучнаас нь өөр нөхцлөөр эсвэл одоогийн нөхцлийг нэлээд өөрчилсөн бол хуучин өрийг бүртгэлээс хасч шинэ өрийг бүртгэлд тусгах ба хоёр өрийн бүртгэлийн үнийн зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс

Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс нь касс дахь бэлэн мөнгө болон анхны гэрээний хугацаа нь гурван сараас богино бодит үнэ цэнийн өөрчлөлтөнд бага өртдөг ба богино хугацааны үүргүүдийг төлж барагдуулахад ашигладаг, хязгаарлагдаагүй, Компани болон бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах, хадгаламжаас бүрдэж байна.

Үндсэн хөрөнгө

(i) Хүлээн зөвшөөрөлт, дараах үеийн үнэлгээ

Үндсэн хөрөнгийн анхны өртөг нь худалдаж авсан үнэ, импортын татвар, нөхөн олгохгүй худалдан авалтын бусад татварууд болон хөрөнгийг байршуулах газар болон зориулалтаар нь ашиглахад бэлэн болгохтой шууд холбоотой гарах зардлаас бүрддэг. Анх бүртгэлд тусгаснаас хойш бодит үнэ цэнийг нь найдвартай тодорхойлох боломжтой хөрөнгүүдийг дахин үнэлгээний дүнгээр буюу дахин үнэлгээ хийсэн өдрийн бодит үнэ цэнээс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр бүртгэнэ. Үндсэн хөрөнгийг ашиглалтанд оруулснаас хойш гарсан зардлуудыг тухайлбал засвар үйлчилгээний зардлыг тухайн зардал гарсан жилийн үр дүнгийн тайланд тусгадаг. Харин тухайн зардал гарснаар хөрөнгийг анх авах үеийн тооцоолсон бүтээмж нэмэгдэж, хөрөнгөөс олох эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг нэмэгдүүлсэн гэдэг нь тодорхой батлагдаж байвал гарсан зардлыг хөрөнгийн өртөг дээр нэмж капиталжуулна.

Компани нь дахин үнэлгээнд хамрагдсан үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнь дансны үнээсээ материаллаг зөрүүтэй болгохгүйн тулд үндсэн хөрөнгөө дахин үнэлэх зарчим баримталдаг. Дахин үнэлгээний нэмэгдлийг дахин үнэлгээний нөөц дансанд тусгана. Харин дахин үнэлгээний бууралтыг тухайн хөрөнгийн хувьд үүссэн өмнөх жилийн нэмэгдлийн дүнг тэг болтол дахин үнэлгээний нөөц дансыг бууруулна. Бусад бүх тохиолдолд дансны үнийн бууралтыг дэлгэрэнгүй орлогын тайланд тусгах зарчим баримталдаг.

(ii) Элэгдэл

Үндсэн хөрөнгийг шулуун шугамын аргаар тэдгээрийн тооцоолсон ашиглагдах жилээр элэгдүүлж дэлгэрэнгүй орлогын тайланд тусгадаг ба тооцоолсон ашиглагдах жилүүд дараах байдалтай байна:

- Барилга 25 жил
- Конторын тоног төхөөрөмж ба тээврийн хэрэгсэл 10 жил
- Тавилга, эд хогшил 10 жил
- Компьютер, дагалдах хэрэгсэл 2 жил

Биет бус хөрөнгө
(i) Үнэлгээ

Компаний худалдан авсан биет бус хөрөнгийг анхны өртгөөс хуримтлагдсан хорогдуулга болон бусад үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тайлагнасан.

(ii) Хорогдуулалт

Ашиглагдах хугацаа тодорхой биет бус хөрөнгийг шулуун шугамын аргаар тэдгээрийн тооцоолсон ашиглагдах жилээр хорогдуулж дэлгэрэнгүй орлогын тайланд тусгадаг. Тооцоолсон ашиглагдах жил дараах байдалтай байна:

- Гүүдвилл, зохиогчийн эрх, патент, лицензТ 10 жил

Үнэ цэнийн бууралт

Компаний хөрөнгөд үнэ цэнийн бууралт үүссэн шинж тэмдэг байгаа эсэхийг тодорхойлохын тулд тайлант хугацааны эцэст хөрөнгийн дансны үнийг хянадаг. Хэрвээ үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрвэл тухайн хөрөнгийн нөхөн төлөгдөх үнэ цэнийг тооцоолдог.

(i) Зээл

Зээлийн болзошгүй алдагдлын санг эсвэл зах зээлийн үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр зээлийг тайлагнадаг ба байнгын хяналт шалгалтын үр дүнд үнэ цэн буурсан буюу муудсан гэж тогтоосон зээлийн дансны үнийг Сангийн Яам болон Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтран баталсан "Активыг ангилах, активын эрсдлийн санг байгуулах, зарцуулах журам"-ын дагуу тодорхойлсон дүн тодорхойлдог.

Компани нь тайлант хугацааны туршид сар бүрийн эцэст "Активыг ангилах, активын эрсдлийн санг байгуулах, зарцуулах журам"-ын дагуу болзошгүй алдагдлын санг байгуулах ба харин тайлант хугацааны эцэст зээлийн зах зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцоолон, түүнийг болзошгүй алдагдлын сантай харьцуулан үзэж, хэрэв бага гарвал санхүүгийн тайланд зах зээлийн үнэ цэнийн бууралт, эрсдлийн сангийн зөрүүгээр бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана. Зээл төлөгдөхгүй нь тодорхой болж, бүх шүүх, эрх зүйн арга хэмжээнүүдийг гүйцэтгэж, эцсийн алдагдлын хэмжээг тогтоосон тохиолдолд зээлийг данснаас хасна.

Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар энэхүү "Активыг ангилах, эрсдлийн сан байгуулах журам"-г шинэчлэн баталсан бөгөөд уг журмаар зээлийн чанар болон хугацааны үзүүлэлтийг тус тусад тодорхойлж, үзүүлэлт тус бүр дээр зээлийг ангилах ба тухайн ангилалаас хамаарч 1 хувиас 100 хувийн эрсдлийн сангийн нөөцийг байгуулахаар баталсан.

Зээлийг чанарын үзүүлэлтүүдээр ангилахад зээлийн баримтын бүрдүүлэлт, зээлдэгчийн санхүүгийн үзүүлэлтүүд, барьцаа хөрөнгийн үнэлгээ болон зээлийн эргэн төлөлтийн хуваарийг өөрчилсөн эсэх зэргийг харгалзан үздэг.

Хэрвээ хожим нь үнэ цэнийн бууралтын алдагдлыг бууруулах үйл явдал гарвал үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаах байдлаар дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

(ii) Санхүүгийн хэрэгслүүдээс бусад актив

Бусад аж ахуйн нэгжээс мөнгө болон бусад санхүүгийн хөрөнгийг авах гэрээний эрх нь бусад санхүүгийн хөрөнгөд хамаарах бөгөөд ийм эрх үүсээгүй тохиолдолд санхүүгийн бус хөрөнгө гэж үзэх ба хөрөнгө хүлээн зөвшөөрөх үндсэн шалгуурыг хангаж, уг хөрөнгийг эзэмших хүчин төгөлдөр эрх Компанид үүссэн тохиолдолд бусад санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Компани тухайн хөрөнгөд үнэ цэнийн бууралт үүссэн гэдэг шинж тэмдэг байгаа эсэхийг тайлант хугацааны эцэст үнэлж тодорхойлдог ба авлагын эрсдлийн санг Сангийн Яам болон Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтран баталсан "Активыг ангилах, активын эрсдлийн санг байгуулах, зарцуулах журам"-ын дагуу тодорхойлдог.

Урьдчилгааг Компаниас төлсөн дүнгээр хэмжих ба бараа материал, үнэ бүхий зүйлийг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар тайлагнадаг. Бараа материалын өртгийг бууруулсан шалтгаан байхгүй болсон эсвэл эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас цэвэр боломжит үнэ цэнэргэн өссөн талаар бодитой нотолгоо байгаа тохиолдолд өртгийг бууруулсан дүнг буцаана.

Хувьцаат капитал

Энгийн хувьцаа болон давуу эрхтэй хувьцааг хувьцаат капиталаар ангилж, бүртгэдэг. Хувьцаат капиталыг анхны өртгөөр нь тайлагнадаг.

Орлого

(i) Хүүгийн цэвэр орлого

Хүүгийн орлого ба зардлыг аккруэль сууриар орлогын тайланд тусгадаг ба хөрөнгийн бодит үр өгөөжийг харгалздаг. Хүүгийн орлого ба зардал нь хөнгөлөлт, урамшууллын хорогдол буюу хүүтэй зээлийн хэрэгслийн дансны үнэ ба бодит хүүгийн аргаар хорогдуулсаар төлөгдөх хугацааны эцэст гарах дүн хоорондын зөрүүгээс бүрдэнэ. Гэхдээ Компани нь зээл анх олгох өртөг зардал болон үйлчилгээний шимтгэлийг бодит хүүгийн аргаар хорогдуулахгүй, шууд тайлант жилийн үйл ажиллагааны орлого, зардлаар бүртгэдэг.

(ii) Хураамж, шимтгэлийн орлого

Хураамж, шимтгэлийн орлого нь харилцагчдад санхүүгийн үйлчилгээ үзүүлснээр авч байгаа төлбөр юм. Хураамж, шимтгэлийн орлогыг тухайн үйлчилгээг үзүүлсэн үед орлогоор бүртгэнэ.

Үйл ажиллагааны түрээсийн төлбөр

Үйл ажиллагааны түрээсийн төлбөрийг түрээсийн гэрээний хугацааны туршид ашиг, алдагдал болон дэлгэрэнгүй орлогын тайланд шулуун шугамын аргаар хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Хүлээн авсан түрээсийн урамшууллыг нийт түрээсийн зардлын бүрдэл хэсэг гэж үзэх ба түрээсийн гэрээний хугацааны туршид хорогдуулж бүртгэдэг.

Орлогын албан татвар

Орлогын албан татвар нь зөвхөн тайлант жилд ногдуулсан орлогын албан татвараас бүрдэнэ.

Тайлант жилийн татвар гэдэг нь тухайн жилийн татвар ногдуулах орлогод тайлагналын өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээг ашиглан ногдуулсан татварын хүлээгдэж буй өр эсвэл авлага болон өмнөх жилүүдийн татварын өртэй холбоотой залруулгаас бүрдэнэ.

Ажилчдын тэтгэмж

Компани нь улсын нийгмийн даатгалын системд ажил олгогчоос төлдөг нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрөөс өөр тэтгэвэрт гарах үеийн тэтгэмжийг олгодоггүй. Компаниас төлөх ажил олгогчийн шимтгэлийг төлөхөөр хуримтлуулсан жилийн дэлгэрэнгүй орлогын тайланд тусгадаг.

Ногдол ашиг

Тайлагналын өдрөөс өмнө буюу тайлагналын өдрөөр зарласан ногдол ашгийг өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Санхүүгийн тайланд илэрхийлсэн хуримтлагдсан ашиг болон тайлант жилийн цэвэр ашиг нь ногдол ашгийг хуваарилах болон төлөх суурь болно.

4. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

	2023 /төгрөгөөр/	2024 /төгрөгөөр/
Касс дах бэлэн мөнгө	4,644,603	5,827,069
Худалдаа хөгжлийн банк /төгрөг/	33,805,208	31,273,999
Худалдаа хөгжлийн банк /юань/	29,007	16,377
Голомт банк /төгрөг/	-	8,886,187
Хаан банк /төгрөг/	99,549,933	16,465,601
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	**137,848,751**	**62,469,233**

5. Зээл, цэвэр

	2023 /төгрөгөөр/	2024 /төгрөгөөр/
Хэвийн зээл	2,053,840,690	2,310,708,086
Хугацаа хэтэрсэн зээл	83,739,983	55,000,000
Чанаргүй зээл. Үүнээс:	**154,741,590**	**134,087,459**
-Хэвийн бус зээл	29,393,977	58,000,000
-Эргэлзээтэй зээл	53,000,000	-
-Муу зээл	72,347,613	76,087,459
Нийт зээл	**2,292,322,2623**	**2,499,795,545**
Зээлийн болзошгүй эрсдлийн сан	(110,383,106)	(93,337,459)
Зээлийн цэвэр дүн	**2,181,939,156**	**2,406,458,086**

Зээлийн үнэлгээг хийхдээ зээлийг хугацаа хэтэрсэн хоногоор бүлэглэж, активын ангиллын журмын дагуу өгөгдсөн хувьд суурилан зээлийн болзошгүй эрсдлийн алдагдлын санг тооцдог.

6. Авлага болон зээлийн хүүгийн авлага

	2023 /төгрөгөөр/	2024 /төгрөгөөр/
Бусад авлага	265,546,190	254,158,875
Найдваргүй авлагын нөөц (*)	-	-
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	22,081,007	38,879,622
Бусад санхүүгийн хөрөнгийн дүн	**287,627,197**	**293,038,497**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр Бусад авлага дансанд ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой урьдчилгаа төлбөр болон дараа тайлангаар үүссэн авлагуудыг бүртгэсэн.

7. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн 2024 болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилүүдийн хөдөлгөөн дараах байдалтай байна:

	2023 /төгрөгөөр/	2024 /төгрөгөөр/
Техник хэрэгсэл	13,931,690	16,890,690
Хуримтлагдсан элэгдэл	(13,026,196)	(13,739,587)
Үндсэн хөрөнгийн дүн	**905,494**	**3,151,103**

8. Бусад өр төлбөр

	2023 /төгрөгөөр/	2024 /төгрөгөөр/
ЭМД, НДШ-ийн өглөг	-	-
ХАОАТ-ын өглөг	3,846,887	-
ААН-ийн Орлогын албан татварын өглөг	164,483	16,017,062
Дансны өглөг	587,480	372,821
Нийт дүн	**4,598,850**	**16,389,883**

9. Хувьцаат капитал

	Энгийн хувьцааны тоо		2023	2024
	2023	2024	/төгрөгөөр/	/төгрөгөөр/
01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	1,900,000	2,500,000	1,900,000,000	2,500,000,000
Нэмж гаргасан	600,000	-	600,000,000	-
12 дугээр сарын 31-ний үлдэгдэл	**2,500,000**	**2,500,000**	**2,500,000,000**	**2,500,000,000**

Хувьцаат капитал нь 2023 болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр нэг бүр нь 1000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 2,500,000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байна.

10. Хүүгийн болон хүүгийн бус орлого

	2023 /төгрөгөөр/	2024 /төгрөгөөр/
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	268,168,411	307,523,254
Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	4,363,595	51,969,387
Харилцах дансны хүүгийн орлого	779,231	2,257,675
Эрсдлийн сангийн бууралтын орлого	-	17,045,647
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	9,166,734	4,414,125
Хүүний орлогын дүн	**273,311,237**	**378,795,963**

11. Хүүгийн бус зардал

	2023 /төгрөгөөр/	2024 /төгрөгөөр/
Цалингийн зардал	157,289,588	160,916,414
Ажилчдад олгосон хөнгөлөлт, тэтгэмж	3,382,000	22,284,822
НДШ-ийн зардал	20,074,258	22,901,134
Мэргэжлийн үйлчилгээний зардал	3,433,000	3,466,000
Зохицуулалтын хураамж	1,380,000	2,700,000
Элэгдлийн зардал	387,860	714,090
Автоматжуулалтын зардал	5,269,990	9,582,210
Бичиг хэргийн зардал	415,620	257,300
Ариун цэврийн зардал	868,000	-
Бусад зардал	1,175,239	4,023,359
Хүүний зардлын дүн	**193,675,555**	**226,845,329**

12. Болзошгүй эрсдлийн зардал

	2023 /төгрөгөөр/	2024 /төгрөгөөр/
Зээлийн болзошгүй эрсдлийн зардал	48,295,686	95,718,486
Болзошгүй эрсдлийн зардлын дүн	**48,295,686**	**95,718,486**

13. Бусад олз, гарз

	2023 /төгрөгөөр/	2024 /төгрөгөөр/
Валютын ханшийн тэгшитгэлийн олз	9,125	2,789
Валютын ханшийн тэгшитгэлийн гарз	(10,171)	(3,418)
Бусад орлого, олзын дүн	**(1,046)**	**(629)**

14. Орлогын татварын зардал

Дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн:

	2024 /төгрөгөөр/	2024 /төгрөгөөр/
Орлогын татварын зардал – тайлант жил	427,672	16,112,079

15. Санхүүгийн баталгаа, батлан даалт

ББСБ нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр харилцагчдын өмнө ямар нэг зээл олгох, санхүүгийн хэрэгслийн зуучлагчаар оролцох гэрээгээр хүлээсэн үүрэггүй ба харилцагчийн өмнөөс аккредитив, санхүүгийн батлан даалт гаргах зэргээр гуравдагч этгээдийн өмнө ямар нэг үүрэг хүлээгээгүй байна.

16. Болзошгүй өр төлбөр

Компанид 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн тайланд тусгаагүй өр төлбөр байхгүй бөгөөд бусдын өмнө ямар нэг үүрэг хүлээгээгүй болно. Болзошгүй өр төлбөр хэмээн тодруулах ямар нэг үйл явдал гараагүй болно.

17.Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэх тухай

Тус компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланд мөнгө угаах болон терроризмтэй холбоо бүхий тайланд нөлөө үзүүлэхүйц үйл явдал гараагүй байна.

18. Тайлагналын дараахь үйл явдал

Компаний 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангийн тайлагналын өдрөөс хойш аудитын дүгнэлт гаргах хүртэлх хугацаанд уг санхүүгийн тайланд нөлөөлөхүйц материаллаг дүн бүхий ажил гүйлгээ гараагүй бөгөөд нөлөө бүхий шийдвэр болон томоохон үйл явдал тохиолдоогүй.

Гүйцэтгэсэн: Аудитор С.Энхтөр /МНБ/